

ЖИЛИЙН ТАЙЛАН | 2018



"АРИЛЖААНЫ ТӨЛБӨР
ТООЦОО" ХХК



АГУУЛГА

МЭНДЧИЛГЭЭ

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Байгууллагын танилцуулга
Зорилго, зорилт
Компанийн бүтэц зохион байгуулалт
Түүхэн товчоон

БИЗНЕСИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үнэт цаасны арилжааны тооцоо, төлбөрийн үйл ажиллагаа
Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны төлбөр тооцоо
Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааны төлбөр тооцоо
Төлбөр тооцооны эрсдэлийн удирдлага
Төлбөр тооцооны систем

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан
Санхүүгийн тайлангууд

ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Хүндэт иргэд, харилцагч, бизнесийн түнш байгууллагууд та бүхний амар мэндийг эрэн мэндчилье.

Хөрөнгийн зах зээл дэх төрийн өмчит мэргэжлийн байгууллагын төрийн төлөөллийг Сангийн яам хэрэгжүүлдэг бөгөөд миний бие Арилжааны төлбөр тооцоо компанийн ТУЗ-ийн даргын үүрэгт ажлыг гүйцэтгэж, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-үүдэд тусгагдсан нийгэм эдийн засгийн хөгжлийн зорилтуудыг ханган биелүүлэхэд компанийн хувь нэмрийг оруулах, үндсэн үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх бэлтгэл хангах, засаглалыг сайжруулах, санхүүгийн болон хүний нөөцийг бэхжүүлэхэд компанийн үйл ажиллагааг чиглүүлэн ажиллалаа.

Компанийн удирдлага, хамт олон, бизнесийн хамтрагч байгууллагууд, харилцагчдын хамтын хүчин чармайлтын үр дүнд 2018 оны зорилтот төвшин, бизнес төлөвлөгөөнд тусгагдсан үндсэн үзүүлэлтүүд бүрэн биелээд байна. Засаглалын стандартыг хэрэгжүүлэх зорилгоор компанийн дүрэмд өөрчлөлт оруулан ТУЗ хараат бус гишүүдтэй ажиллах боломж бүрдлээ. Хуримтлагдсан ашиг нэмэгдсэнээр төлбөр тооцооны T+2 горим, DvP зарчимд шилжих, төлбөрийн баталгааны сан бүрдүүлэхэд компанийн зүгээс оруулах хөрөнгийн боломжит эх үүсвэр нэмэгдэв.

2018 оны ажлын үр дүнгээ баталгаажуулан Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банкны гаргасан тайлан, зөвлөмжийн дагуу 2019 онд урьдчилсан төлбөрт тогтолцооноос олон улсын стандартыг хангасандараа төлбөрт T+2 тогтолцоонд шилжих, системийн шинэчлэлийг эхлүүлэхэд компанийн хувьцаа эзэмшигч Сангийн яам, Төлөөлөн удирдах зөвлөл онцгой анхаарал хандуулах болно.

Та бүхэнд ажлын амжилт, сайн сайхныг хүсэж, хөрөнгийн зах зээл хөгжин дэвжихийн өрөөл өргөө.

Хүндэтгэн ёсолсон,

Б.СҮХ-ОЧИР

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм таны амрыг эрэхийн ялдамд, хөрөнгийн зах зээлийн тулгын чулууг тавилцсан Төлбөр тооцоо хадгаламжийн алба байгуулагдсаны 28 жил, Арилжааны Төлбөр Тооцоо ХХК байгуулагдсаны 3 жилийн ойн мэндийг хамт олныхоо зүгээс өргөн дэвшүүлье.

Компанийн 2018 оны бизнес төлөвлөгөөний хэрэгжилт, зорилтот түвшин, эдийн засгийн үзүүлэлтүүдийн биелэлтийг гэнэхүү тайлангаар дамжуулан танилцуулж байгаадаа баяртай байна.

Өнгөрсөн 2018 он манай байгууллагын хувьд ололт амжилтаар дүүрэн жил болж өнгөрлөө. Бид төрийн болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, гадаад дотоодын харилцагч иргэд байгууллагын 34.5 тэрбум төгрөгийн Засгийн газрын бондын, 0.7 тэрбум төгрөгийн компанийн бондын, 210.0 тэрбум төгрөгийн хувьцааны, нийт 245.2 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог амжилттай хийж гүйцэтгэв.

Компанийн 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд Үндэсний аудитын газраас хийсэн аудитын тайлангаар санхүүгийн аливаа “зөрчилгүй” санал дүгнэлттэй шалгагдлаа. Аудитлагдсан санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр 2018 онд 1,337.7 сая төгрөгийн орлого олсон нь өмнөх онтой харьцуулахад 846.3 сая төгрөгөөр буюу 2.7 дахин өссөн бөгөөд 2018 оны төлөвлөгөөнөөс 758.6 сая төгрөгийн илүү орлого олж төлөвлөгөө 231.0 хувиар биелсэн үзүүлэлттэй байна.

Жилийн орлого үрдүнгийн үзүүлэлтээр 898.6 сая төгрөгийн татварын өмнөх, 805.9 сая төгрөгийн татварын дараах ашигтай ажилласнаар хуримтлагдсан ашгийн хэмжээ 858.6 сая төгрөгт хүрээд байна.

Цаашид хөрөнгийн захын төлбөр тооцоог олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх, тооцооны гишүүн элсүүлэх, дараа төлбөрт тогтолцоонд шилжих, эрсдэлийг бүрэн удирдах чухал ажлууд хүлээгдэж байна.

Дээрх амжилтад хүрэхийн төлөө мөр зэрэгцэн зүтгэсэн, цаашдын зорилтуудыг хэрэгжүүлэхэд хамтран оролцох баг хамт олон, төрийн болон мэргэжлийн байгууллагууд, нийт харилцагчдаа чин сэтгэлийн талархал илэрхийлж ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Гүйцэтгэх захирал

О.ЭРДЭНЭГЭРЭЛ

1

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА



БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

ЭРХЭМЗОРИЛГО

Үнэт цаасны арилжааны тооцоо, төлбөрийн үйл ажиллагааг олон улсын стандартын дагуу зохистой гүйцэтгэж, хөрөнгийн захын хөгжлийн тогтвортой өсөлтийг дэмжинэ

АЛСЫН ХАРАА

IOSCO-ийн стандартыг хангасан CCP (Central Counterparty) клирингийн байгууллага болно

ҮНЭТ ЗҮЙЛС

- Түүх, мэдлэг, туршлага
- Мэргэшсэн баг хамт олон
- Бизнесийн хамтрагч, харилцагч
- Тооцооны болон төлбөрийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл


ЗАРЧМУУД

- Хууль дүрэм, олон улсын стандартыг чанд мөрдөх
- Шударга, шуурхай, ил тод, нээлттэй байх
- Зөв үзэл, бүтээлч сэтгэлгээг дэмжин хөгжүүлэх

УРИА

- Итгэлтэй ирээдүйн төлөө

БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



"Арилжааны төлбөр тооцоо" ХХК нь 100% төрийн өмчтэй, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэгч нь Сангийн яам бөгөөд Сангийн сайдын тушаалаар томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлтэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ-ийн дарга:

Б.СҮХ-ОЧИР (Сангийн Яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга)

ТУЗ-ийн гишүүд:

Л.СОНОР (Сангийн Яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга)

Б.ЛХАГВА-ОЧИР (Сангийн Яамны Төрийн захиргаа удирдлагын газрын Санхүүгийн мэдээллийн технологийн хэлтсийн дарга)

Т.АМАРСАЙХАН (Монголбанкны Дотоод аудит, хяналт шалгалтын газрын захирал)

Д.БАЛЖИННЯМ (Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Стратегийн удирдлага, зохицуулалтын газрын ахлах РЕФЕРЭНТ)

Э.ДУЛАМСҮРЭН (Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн)

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:

Э.ХОРОЛСҮРЭН ("Арилжааны төлбөр тооцоо" ХХК-ийн хуулийн зөвлөх)

ТҮҮХЭНТОВЧООН

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН КЛИРИНГ, ТӨЛБӨР
ТООЦООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮҮХ

Засгийн Газрын 1991 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 22 дугаар тогтоолоор Монголын Хөрөнгийн Бирж байгуулагдахад түүний бүтцэд Төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн албыг анх байгуулав.

1991

1999



1999 онд Төлбөр тооцооны системийн шинэчлэл явагдав.

2003



Засгийн газрын 2003 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 72 дугаар тогтоолоор Төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагааг МХБ-ийн бүтцээс салган, Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв байгуулагдав.

2007



2007 онд Төлбөр тооцоо хадгаламжийн системийг шинэчлэн E-Clearing House системийг нэвтрүүлэв.

2010



2011 онд Монгол банкны оролцогчоор бүртгэгдэж RTGS системд холбогдов.

2011

2012






“АРИЛЖААНЫ ТӨЛБӨР
ТООЦОО” ХХК

2016 онд “ҮЦТТХТ” ХХК-ийг өөрчлөн зохион байгуулж “АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО” ХХК байгуулагдав.

2016

millennium
information technologies

2012 онд “МИЛЛЕННИУМ АЙТИ” (MIT) систем нэвтэрснээр Төлбөр гүйцэтгэх банкууд бий болов.

-  -Хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр төлбөр тооцоо гүйцэтгэсэн хугацаа
-  -Бэлэн болон бэлэн бусаар төлбөр тооцоо гүйцэтгэсэн хугацаа
-  -Бэлэн бус төлбөр тооцоонд шилжсэн хугацаа

КОМПАНИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

2015 ОН	Засгийн газрын 2015 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 147 тоот тогтоол, Сангийн сайдын 2015 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 280, 2015 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 284 тоот тушаалаар "Арилжааны төлбөр тооцоо" ХХК-ийг байгуулж, дүрмийг батлав.
2016 ОНЫ 4-Р CAP	2016 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр "Арилжааны төлбөр тооцоо" ХХК анхны төлбөр тооцоогоо хийж гүйцэтгэв.
2016 ОНЫ 8-Р CAP	ТУЗ-ийн 2016 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн 06 тоот тогтоолоор үндсэн үйл ажиллагааны журмуудыг баталлаа.
2016 ОНЫ 10-Р CAP	2016 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагуудтай "Хамтран ажиллагааны санамж бичиг"-т гарын үсэг зурав.
2017 ОНЫ 4-Р CAP	Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 4-р сарын 12-ны өдрийн 73 тоот тогтоолоор үнэт цаасны арилжааны тооцооны болон төлбөрийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгов. 2017 оны 4-р сарын 28-ны өдөр Төлбөр тооцооны системийн шинэчлэл хийх зорилго бүхий "DvP-ийн ажлын хэсэг" байгуулагдав.
2018 ОНЫ 1-Р CAP	Банк хоорондын их дүнтэй гүйлгээний RTGS системийн II хувилбарт шилжив.
2018 ОНЫ 4-Р CAP	Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 4.0 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэв. Харилцагчийн дансны бүтцийг сайжруулах зорилгоор "холболтын данс"-ны мөнгөн үлдэгдлийг Үнэт цаасны компани (ҮЦК) тус бүрээр салгав.
2018 ОНЫ 5-Р CAP	ACG (Asia Pacific Central Securities Depository Group) олон улсын байгууллагын гишүүнээр элсэв. Эрсдэлийн удирдлагын багц журмын төслийг боловсруулан СЗХ-оор батламжлуулахаар хүргүүлэв
2018 ОНЫ 10-Р CAP	Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны хамтрагч гишүүнээр элсэв. Харилцагчдад хүргэх үйлчилгээг хялбарчлах зорилго бүхий "Онлайн үйлчилгээ"-ний программ нэвтрүүлэв.
2018 ОНЫ 11-Р CAP	Нягтлан бодох бүртгэлийн Solarsys программыг үйл ажиллагаандаа ашиглаж эхлэв. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлав. Бүтээмж, чанарыг сайжруулах "Ажлын байрны соёл, 5S, кайзен саналын систем" хөтөлбөрийг батлав.


2

БИЗНЕСИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ ТООЦОО, ТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монголын хөрөнгийн зах зээл дээр хувьцаа, бонд гэсэн 2 төрлийн үнэт цаас арилжаалагдаж байгаа бөгөөд анхдагч болон хоёрдогч зах зээлийн төлбөр тооцоо T+0, T+1 горимуудаар хийгдэж байна.

Үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааны тооцоо, төлбөрийн үйл ажиллагааны горим



ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО T+0/

Захиалга өгөх - ҮЦК

Мөнгө байршуулах – АТТ дахь өөрийн нэрийн тооцооны дансанд

Мөнгө авах – ҮЦК-нд мөнгө хүссэн өргөдөл өгнө. ҮЦК өргөдлийг АТТ-д хүргэж мөнгийг арилжааны банк дахь нэрийн дансанд шилжүүлнэ.

Төлбөр хийгдэх нөхцөл – Урьдчилгаа төлбөр 100%, төлбөр хийгдэх хугацаа T+0

Төлбөр тооцооны эрсдэл үүсэх нөхцөл – Харилцагчаас ирүүлсэн захиалгыг МХБ-ийн арилжааны системд оруулахдаа мөнгөн төлбөрийг хангалттай хэмжээнд байршуулсан эсэхийг шалгадаг тул төлбөрийн эрсдэл үүсэхгүй. Эрх бүхий этгээдээс арилжаа амжилттай болсныг зарлах хүртэл хугацаагаар захиалга өгсөн харилцагчдын мөнгөн хөрөнгийн захиалгын гүндтэй тэнцэх хэмжээний төлбөрийг тусгаарлаж, төлбөрийн эрсдэл үүсэхээс хамгаалдаг.


Зах зээлд оролцогчдын шимтгэлийн тооцоо – ҮЦК харилцагчаас авах шимтгэлийн хэмжээг программаар тооцох ба хэлцэл шалгах явцад төлбөрөөс суутгагдан АТТ дахь ҮЦК-ийн дансанд байршина.

МХБ-ээс арилжааны хэлцлийг хүлээн авч төлбөр тооцоог хийж гүйцэтгээд харилцагчийн тооцооны дансанд мөнгө байршуулах ба мөнгө хүссэн өргөдлийн дагуу арилжааны банк дахь харилцагчийн нэрийн дансанд шилжүүлнэ

ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ТООЦОО

2018 онд үнэт цаасны анхдагч зах зээлд Засгийн газрын бонд, компанийн бондын арилжаа хийгдээгүй бөгөөд шинээр IPO хийсэн 7 хувьцаат компанийн 31,4 тэрбум төгрөгийн төлбөр, тооцоог хийж гүйцэтгэлээ.

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны тооцоо



(Сая төгрөгөөр)

Он	Засгийн газрын бонд	Компанийни бонд	Хувьцаа	Нийт
2016*	224,724.0	-	-	224,724.0
2017	630,204.9	6,000.0	1,338.8	637,543.7
2018	-	-	31,443.2	31,433.2
Дүн	854,928.9	6,000.0	2,772.0	893,700.9

ҮНЭТЦААСНЫХОЁРДОГЧЗАХЗЭЭЛИЙНАРИЛЖААНЫТӨЛБӨРТООЦОО/Т+1/

Захиалга өгөх – ҮЦК

Мөнгө байршуулах – ҮЦК-ийн сонгосон арилжааны банканд нээлгэсэн эскроудансанд Мөнгө авах – ҮЦК-аас зарлагын гүйлгээ хийх зөвшөөрөл авч, эскроу данснаас бэлэн болон бэлэн бусаар мөнгөө авна.

Төлбөр хийгдэх нөхцөл – Урьдчилгаа төлбөр 100%, төлбөр хийгдэх хугацаа Т+1


Төлбөр тооцооны эрсдэл үүсэх нөхцөл – Арилжаа хийгдэх явцад төлбөр хийгдсэн эсэхийг шалгах боломжгүй. МIТ системээс төлбөрийн мэдээ хүлээж аваад эскроу дансанд мөнгө хүрэлцэхгүй бол Т+1 өдрийн 9.00 цаг хүртэл хугацаанд төлбөрийг гүйцээж байршуулах боломж олгодог. Хэрэв харилцагч мөнгөө байршуулахгүй бол ҮЦК хариуцна. Эрсдэлийн сан байхгүй, одоогоор эрсдэл үүссэн нөхцөл байдал гараагүй.

Зах зээлд оролцогчдын шимтгэлийн тооцоо – ҮЦК харилцагчаас авах шимтгэлийн дүнг төлбөргүйцэтгэгч банканд өгч, банк харилцагчийн төлбөрөөс шимтгэлийг суутгаж авна.

MIT системээс төлбөрийн мэдээ хүлээж аваад банк доторх гүйлгээг хийж гүйцэтгэсний эцэст Т+1 өдрийн 9-11 цагт багтаан банк хоорондын гүйлгээг цэвэршүүлсэн дүнгээр АТТ-д шилжүүлнэ.

Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааны тооцоо

2018 онд үнэт цаасны хоёрдогч зах зээлд МХБ-ээр нийт 252 удаагийн арилжаа явагдсан бөгөөд үүнээс 252 удаагийн арилжаанд 178,569.0 сая төгрөгийн хувьцааны, 83 удаагийн арилжаанд нь 34,486.9 сая төгрөгийн ЗГҮЦ-ны, 17 удаагийн арилжаанд 723,716.4 сая төгрөгийн компанийн бондын, нийт 213,779.7 сая төгрөгийн хоёрдогч зах зээлийн арилжаа явагдсан бөгөөд дээрх дүнгээр төлбөр тооцоог гүйцэтгэлээ.



Он	Засгийн газрын бонд	Компанийн бонд	Хувьцаа	Нийт	Төлбөрийн цэвэршүүлсэн дүн
2016*	15,358.1	-	37,247.0	52,605.0	8,958.0
2017	143,285.4	4,295.6	75,110.2	222,691.2	27,737.5
2018	34,486.9	723.7	178,569.0	213,779.7	33,395.7
Дүн	193,130.4	5,019.3	290,926.2	489,075.9	70,091.2

Арилжааны төлбөр тооцоо ХХК нь арилжааны тооцоог хийж мөнгөн төлбөрийг Монгол банкны RTGS системээр дамжуулан Төлбөр гүйцэтгэх 4 банкны хооронд цэвэршүүлсэн дүнгээр хийж гүйцэтгэдэг бөгөөд төлбөр хийгдсэн тухай ҮЦТХТ ХХК-д мэдэгдэж, үнэт цаасны шилжүүлгийн MIT CSD систем ашиглан хийж гүйцэтгэдэг.

ТӨЛБӨР ТООЦООНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Үнэт цаасны арилжааны төлбөрийн одоогийн систем нь урьдчилсан төлбөрт зарчимд суурилж байгаа тул төлбөрийн эрсдэл үүсэх нөхцөл харьцангуй бага бөгөөд төлбөрийг урьдчилан 100% байршуулаагүй тохиолдолд захиалгавивсэн ҮЦК хариуцлага хүлээхээр Санхүүгийн зохицуулах хорооноос 2015 онд шийдвэр гаргасан.

Монгол Улсын хөрөнгийн зах зээл дээрх үнэт цаасны төлбөр тооцооны өнөөгийн горимоос үүдэн үнэт цаасны арилжааны өдрийн дундаж хэмжээ, түүндотор хувьцааны арилжааны өдрийн дундаж хэмжээ хангалтгүй, түүнчлэн арилжаанд оролцох боломжит институтуудын зах зээлд итгэх итгэл сул байгаа нь DvP механизм дээр суурилсан Т+2 горимыг өнгөц төдий бус, агуулга болон зарчмын хувьд иж бүрэн нэвтрүүлэх шаардлагыг бий болгож байна.


2012 онд анх DvP механизм дээр суурилсан T+3 горимыг хэрэгжүүлэх оролдлого хийсэн боловч зах зээлийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадаагүй. Бид энэхүү алдаагаа дахин давтахгүйн тулд зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудтай санал солилцох, ажлын хэсэг байгуулж хамтран ажиллах, үүсч болзошгүй эрсдэлийг хэрхэн удирдах талаар Эрсдэлийн удирдлагын багц журмын төслийг боловсруулан батламжлуулахаар СЗХ-нд хандах зэрэг ажлуудыг гүйцэтгээд байна.

Хөрөнгийн зах зээлд үнэт цаасны төлбөр тооцооны DvP механизмыг нэвтрүүлснээр - үнэт цаасны төлбөр тооцоог T+2 өдөрт гүйцэтгэх,
 - төлбөрийн баталгааны сан, маржин тогтолцоо бий болгох,
 - төлбөр тооцооны байгууллагын хоёр шатлалт гишүүнчлэлийг нэвтрүүлэх
 -МХБ, АТТ, ҮЦТХТ компаниудын хоорондох мэдээлэл дамжуулалт, боловсруулалтын гар ажиллагааг боловсронгуй болгох зэрэг ач холбогдолтой.

Хөрөнгийн зах зээл гэдэг нь дан ганц хөрөнгийн бирж биш бөгөөд дэд бүтцийн байгууллагууд /төлбөр тооцоо, хадгаламж, кастодиан, андеррайтер, ХОС, менежментийн компани, дилер, брокер г.м/-ын бие даасан үйл ажиллагааг дэмжиж ажиллах нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд чухал нөлөөтэй.

СТАТИСТИКСУДАЛГАА


Үнэт цаасны арилжаанд оролцогчид /үнийн дүнгээр/ Арилжаанд оролцсон тоо /үнийн дүнгээр/



(Мян.төгрөгөөр)

Үзүүлэлт	2017		2018		
	Арилжаанд оролцсон тоо	Арилжааны үнийн дүн	Арилжаанд оролцсон тоо	Арилжааны үнийн дүн	
Гадаадын	ААН	2,972	10,595.7	1,955	89,176.7
	Иргэн	1,902	24,318.6	3,565	6,961.0
Дотоодын	ААН	3,123	657,613.2	4,709	99,948.1
	Иргэн	30,072	167,707.4	56,313	49,127.1

2010-2018 онд Арилжагдсан үнэт цаас, үнийн дүнгээр /Мян.төгрөгөөр/



ТӨЛБӨР ТООЦООНЫ СИСТЕМ

Арилжааны төлбөр тооцоо ХХК-ийн үндсэн үйл ажиллагаанд И-Клиринг Хаус болон MIT системийн дэд систем болох MIT CSD системийг ашиглаж байна.

Доор схемээр одоогийн ашиглагдаж буй системийн үнэт цаасны төлбөр тооцоонд гүйцэтгэж буй функц, үүргийг харуулав.



E-CLEARING HOUSE

Бид төлбөр тооцооны үйл ажиллагаанд И-Клиринг хаус системийг ашиглаж байгаа бөгөөд энэ нь 2007 онд программ хангамжийн "ЕСМ" ХХК-аар хөгжүүлэлт хийж нэвтрүүлсэн, үнэт цаасны төлбөр тооцоо, мөнгөн хөрөнгө болон хадгаламж, өмчлөх эрх бүртгэлийн үйл ажиллагааг автоматжуулсан систем юм. Энэхүү системийг 2011 онд "Үндэсний төлбөр тооцооны зөвлөл"-өөс гаргасан шийдвэрийн дагуу Монгол банкны банк хоорондын төлбөр тооцоонд холбосон. 2012 онд CSD системийг үнэт цаасны хадгаламж, өмчлөх эрх бүртгэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн хэдий ч мэргэжлийн байгууллагуудын тайлан судалгаа, шимтгэл хураамжийн тооцоолол шинээр нэвтрүүлсэн системд гүйцэтгэх боломжгүй байсан учир И-Клиринг хаус системийг ҮЦТХТ ХХК, АТТ ХХК давхар ашиглаж байна.

Энэхүү системээр үнэт цаасны мөнгөн төлбөрийн гүйлгээг Төлбөр гүйцэтгэх 4 банк (Худалдаа Хөгжил, Хаан, Хас, Голомт)-ны хооронд Монгол банкны банк хоорондын төлбөр тооцоогоор дамжуулан гүйцэтгэх, мөн анхдагч зах зээлийн арилжааны төлбөрийг 100% урьдчилан АТТ ХХК-ийн өөрийн дансанд байршуулах, мэргэжлийн байгууллагуудын шимтгэлийн тооцоолол болон шаардлагатай төлбөр тооцооны мэдээллийг оролцогчид руу илгээх зэрэг үйл ажиллагааг хийж гүйцэтгэдэг.

МИЛЛЕНИУМ АЙ ТИ СИ ЭС ДИ (MIT CSD) СИСТЕМ

2012 онд Монголын хөрөнгийн бирж болон Лондонгийн хөрөнгийн биржийн хооронд байгуулсан мастер гэрээний хүрээнд MIT системийг нэвтрүүлсэн бөгөөд энэхүү системийн дэд систем болох MIT CSD систем нь үнэт цаасны хадгаламж, өмчлөх эрх бүртгэлийн үйл ажиллагаа болон арилжааны мэдээ, төлбөр тооцооны тайлан гаргах функцтэй вебхандлалт программ хангамж юм. Энэхүү системээр үнэт цаасны төлбөр тооцоогүйцэтгэхэд АТТ ХХК, Төлбөр гүйцэтгэх 4 банк, ҮЦК-ууд нь арилжааны мэдээлэл болон төлбөр тооцооны тайлан хүлээн авах эрхүүрэгтэйгээр системд нэвтрэн ажиллаж байна.

MIT CSD систем нь тооцооны үүрэг функцийг, И-Клиринг хаус систем нь төлбөрийн үүргийг тус тус гүйцэтгэж байгаа хэдий ч хоорондоо мэдээлэл солилцох интерфэйсийн холболтгүй учир гар аргаар мэдээлэл солилцох, мөнгө болон үнэт цаасны нэгдсэн хяналт тавих боломжгүй, төлбөр тооцооны T+2/3 горимоор DvP зарчмыг хэрэгжүүлэхэд эрсдэлийн удирдлагын функцгүй зэрэг нь шинээр төлбөр тооцооны систем нэвтрүүлэх үндсэн шаардлагыг бий болгож байна.



ХАРИЛЦАГЧ БАЙГУУЛЛАГУУД



САНГИЙН ЯАМ



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

FINANCIAL REGULATORY COMMISSION
OF MONGOLIA



MONGOLIAN
STOCK EXCHANGE



ҮЦТХТ



Asia-Pacific CSD Group



ХААН БАНК



ТДВ
ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК



ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ



ХАСБАНК

Амьдралд - ашид хамтдаа.



**МОНГОЛЫН
ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ**

Mongol Securities Exchange



MCE
MONGOLIAN COMMODITY
EXCHANGE





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.15 № 06/446
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

АУДИТЫН ТАЙЛАН

АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО
ҮЦК ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
О.ЭРДЭНЭГЭРЭЛ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан		(төгрөгөөр)	
Д/Д	Үзүүлэлт	2018 ОНЫ 1-Р САРЫН 01	2018 ОНЫ 12-Р САРЫН 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	6,188,656,275.49	5,806,051,621.88
1.1.2	Дансны авлага	8,042,162.56	5,621,917.81
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	9,240.00	
1.1.4	Бусад авлага		19,852.00
1.1.6	Бараа материал	7,865,280.00	336,700.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	595,630.63	595,630.63
1.1.11	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,205,168,588.68</u>	<u>5,812,625,722.32</u>
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	44,633,950.90	57,778,519.97
1.2.2	Биет бус хөрөнгө	1,287,603.20	11,437,603.20
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	936,123.03	1,914,881.40
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	2,791,716.67	
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	49,649,393.79	71,131,004.57
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,254,817,982.47</u>	<u>5,883,756,726.89</u>
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	4,400,000.00	810.00
2.1.1.3	Татварын өглөг	3,912,969.17	58,491,150.48
2.1.1.4	НДШ-ийн өглөг		460,000.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		954,699,704.48
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	<u>2,181,436,508.78</u>	<u>1,013,651,664.96</u>
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	936,123.03	1,914,881.40
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	936,123.03	1,914,881.40

2.2	Өр төлбөрийн нийт дүн	<u>2,181,436,508.78</u>	<u>1,015,566,546.36</u>
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч : - төрийн	950,893,520.75	4,000,000,020.75
2.3.6	Хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдэл		9,560,000.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	3,049,106,500.00	
2.3.9	Хуримтлагдсан ашиг	72,445,329.91	858,630,159.78
2.3.11	Эздийн өмчийн дүн	4,072,445,350.66	4,868,190,180.53
2.3.20	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	<u>6,254,817,982.47</u>	<u>5,883,756,726.89</u>

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Борлуулалтын орлого (цэвэр)	491,400,782.68	1,018,830,521.28
Нийт ашиг (алдагдал)	129,762,319.97	1,018,830,521.28
Арилжааны шимтгэлийн орлого	351,953,581.22	1,018,830,521.28
Хүүний орлого	69,067,756.46	318,809,599.58
Бусад орлого	70,379,445.00	49,000.00
Ерөнхий ба удирдлагын зардал	341,748,530.78	416,857,794.82
Бусад зардал	19,889,931.93	22,174,710.00
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		19,656.00
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-72,419.48
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	129,762,319.97	898,603,852.56
Орлогын татварын зардал	7,032,562.90	92,750,762.91
Татварын дараахь ашиг (алдагдал)	122,729,757.07	805,853,089.65
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	122,729,757.07	805,853,089.65
Бусад дэлгэрэнгүй орлого		
Орлогын нийт дүн	122,729,757.07	805,853,089.65
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ДЭЭР
БҮРТГЭЛТЭЙ ГИШҮҮН ҮЦК-УУДЫН ЖАГСААЛТ

№	Код	Гишүүн компанийн нэрс	Үйл ажиллагааны чиглэл			
			Брокер	Дилер	Андер-райтер	Хөрөнгө оруулалтын зөвлөх
1	ACE	"ACE энд Т Капитал ҮЦК"ХХК	✓	✓	✓	✓
2	ALTN	"Алтан хоромсог ҮЦК" ХХК	✓	✓		
3	APS	"Азиа Пасифик Секьюритис ҮЦК"ХХК	✓	✓		
4	ARD	"Ард капитал групп ҮЦК"ХХК	✓	✓	✓	
5	ARGB	"Аргай бэст ҮЦК"ХХК	✓	✓		
6	BATS	"Батс ҮЦК"ХХК	✓	✓		
7	BDSC	"Бидисек ҮЦК"ХК	✓	✓	✓	✓
8	BLAC	"Блэкстоун интернэйшнл ҮЦК"ХХК	✓	✓		
9	BSK	"Блүмсбюри секьюритис ҮЦК" ХХК	✓	✓	✓	
10	BULG	"Блюская секьюритиз ҮЦК" ХК	✓	✓		
11	BUMB	"Булган брокер ҮЦК" ХХК	✓	✓		
12	BZIN	"Бумбат-Алтай ҮЦК" ХХК	✓	✓	✓	
13	CAPM	"Мирэ Эссэт Секьюритис Монгол ҮЦК" ХХК	✓	✓	✓	✓
14	CTRL	"Капитал маркет корпораци ҮЦК" ХХК	✓	✓	✓	
15	DCF	"Централ секюритийз ҮЦК" ХХК	✓			
16	DELG	"Ди Си Эф" ХХК	✓	✓		
17	DRBR	"Дэлгэрхангай секюритиз ҮЦК" ХХК	✓	✓		
18	ECM	"Дархан брокер ҮЦК" ХХК	✓	✓		
19	ECM	"Еврази капитал холдинг ҮЦК" ХК	✓	✓	✓	✓
20	FCX	"Эф Си Икс ҮЦК" ХХК	✓	✓	✓	
21	FRON	"Фронттиер ҮЦК" ХХК	✓	✓		
22	GATR	"Гацуурт трейд ҮЦК" ХХК	✓	✓		
23	GAUL	"Гаули ҮЦК" ХХК	✓	✓	✓	
24	GDEV	"Гранддевелопмент ҮЦК" ХХК	✓	✓		
25	GDSC	"Гүүдсек ҮЦК" ХХК	✓	✓	✓	✓
26	GLMT	"Голомт капитал ҮЦК" ХХК	✓		✓	✓
27	GNDX	"Гендекс ҮЦК" ХХК	✓	✓		
28	HUN	"Хүннү Эмпайр ҮЦК" ХХК	✓	✓		

№	Код	Гишүүн компани	Үйл ажиллагааны чиглэл			
			Брокер	Дилер	Андер-райтер	Хөрөнгө оруулалтын зөвлөх
29	INVC	"Инвекстор капитал ҮЦК" ХХК	☑	☑	☑	
30	LFTI	"Лайфтайм инвестмент ҮЦК" ХХК	☑	☑	☑	
31	MERG	"Мэргэн санаа ҮЦК" ХХК	☑			
32	MIBG	"Эм Ай Би Жи" ХХК ҮЦК	☑	☑	☑	
33	MICC	"Эм Ай Си Си" ХХК	☑	☑	☑	
34	MNET	"Ард секьюритиз ҮЦК" ХХК	☑	☑	☑	☑
35	MONG	"Монгол секюритиес ҮЦК" ХХК	☑	☑		
36	MSDQ	"Масдак үнэт цаасны компани" ХХК	☑	☑		
37	MSEC	"Монсек ҮЦК" ХХК	☑	☑	☑	
38	NOVL	"Новел инвестмент ҮЦК" ХХК	☑	☑		☑
39	NSEC	"Нэйшнл сэкюритис ҮЦК" ХХК	☑	☑	☑	☑
40	SANR	"Санар ҮЦК" ХХК	☑	☑		
41	SECP	"Сикал ҮЦК" ХХК	☑	☑	☑	☑
42	SGC	"Эс Жи Капитал ҮЦК" ХХК	☑	☑	☑	☑
43	SILS	"Силвэр лайт секюритиз ҮЦК" ХХК	☑			
44	STIN	"Стандарт инвестмент ҮЦК" ХХК	☑	☑	☑	☑
45	TABO	"Таван богд ҮЦК" ХХК	☑			
46	TCHB	"Тулгат чандмань баян ҮЦК" ХХК	☑			
47	TDB	"Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК	☑		☑	
48	TNGR	"Тэнгэр капитал ҮЦК" ХХК	☑	☑	☑	☑
49	TTOL	"АПЕКС КАПИТАЛ ҮЦК" ХХК	☑	☑		
50	UNDR	"Өндөрхаан инвест ҮЦК" ХХК	☑	☑		
51	ZGB	"Зэт жи би ҮЦК" ХХК	☑	☑		
52	ZRGD	"Зэргэд ҮЦК" ХХК	☑	☑		



MONGOLIAN SECURITIES CLEARING &
SETTLEMENT Co.,Ltd



<https://www.facebook.com/att.ccp>



Info@mscc.mn



https://twitter.com/MSCC_Mongolia



www.mscc.mn



7011-0104, 7011-3672

ЖИЛИЙН ТАЙЛАН | 2018



"АРИЛЖААНЫ ТӨЛБӨР
ТООЦОО" ХХК